



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Зүүнхараа Политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СЭА-2026/019/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb @audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

Г МАНДАЛ СУМЫН ЗҮҮНХАРАА Г  
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН  
ЗАХИРАЛ С.СУВДАА ТАНАА Г

2026.02.25 № СЭА-2026/019/НА-СТА-ТШЗ

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын Зүүнхараа Политехник коллежийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Тооцооллын алдаанаас шалтгаалан 4,288.8 мянган төгрөгийн цалинг илүү бодож олгосон,
- Сахилгын шийтгэл тооцогдсон ажилтанд сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа болоогүй байхад ур чадварын нэмэгдэлд 619.2 мянган төгрөгийн цалин бодож олгосон,
- Дотуур байрны багшид 1,272.6 мянган төгрөгийн мэргэшлийн зэргийн нэмэгдэл цалинг илүү бодож олгосон,
- Тайлант онд өндөр насны тэтгэврээ тогтоолгон, төрийн албанаас бүрмөсөн чөлөөлөгдөж, гэрээгээр ажиллаж буй багшид 403.9 мянган төгрөгийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгосон,

- Зоорь болон дотуур байр түрээсэлсний орлогын 40 хувь болох 2,599.8 мянган төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй, түрээслэх зөвшөөрлийг ТӨБЗГ-аас аваагүй,
- Төлбөр тооцоог хянаж баталгаажуулаагүйгээс нийгмийн даатгалын тайланд цалинг илүү тайлагнан 36,185.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн.

Аудитаар илэрсэн дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 2 дахь, 5 дугаар хавсралтын 6 дахь, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 тоот тогтоолын 2 дахь заалтуудтай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Мандал сумын Зүүнхараа Политехник коллеж нь тайлант онд ГОУХАН олон улсын байгууллагаас хамтын ажиллагааны хүрээнд 173,855.1 мянган төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, ашиглалтын хугацаа дууссан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч дахин ашиглах боломжтой 910,045.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасаж, ашиглах хугацааг сунгаж орлогод авсан байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус коллеж нь 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 2 зорилтын хүрээнд 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 82.4 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Тод-руулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4	27,741,342.61	152,527,051.64
312	Банканд байгаа бэлэн мөнгө		27,741,342.61	152,527,051.64
3121	Төгрөг		27,741,342.61	152,527,051.64
31211	Төрийн сангийн харилцах		27,741,342.61	152,527,051.64
33	АВЛАГА	5	29,623,041.49	36,379,995.01
331	Ажиллагчидтай холбогдсон авлага		28,103,041.49	36,184,995.01
333	Татаас, санхүүжилтийн авлага			195,000.00
335	Бусад авлага		1,520,000.00	
3351	Байгууллагаас авах авлага		1,520,000.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	6	294,575,407.00	411,699,160.80
351	Түүхий эд материал		1,329,900.00	1,479,900.00
3511	Тусгай зориулалттай материал			150,000.00
3513	Эм боох материал		1,329,900.00	1,329,900.00
354	Хангамжийн материал		277,166,757.00	394,340,510.80
3541	Бичиг хэргийн материал			500,000.00
3542	Аж ахуйн материал		41,961,349.00	43,292,049.00
3543	Сэлбэг хэрэгсэл		110,251,164.00	110,251,164.00
3545	Барилгын засварын материал		37,157,400.00	95,136,100.00
3546	Хүнсний материал		6,946,774.00	1,461,797.80
3547	Бусад хангамжийн материал		80,850,070.00	143,699,400.00
356	Мал амьтад		16,078,750.00	15,878,750.00
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		351,939,791.10	600,606,207.45
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	2,567,558,806.29	3,106,693,668.80
392	Биет хөрөнгө		1,884,696,806.15	2,411,545,368.86
39201	Барилга, байгууламж, орон сууц		1,640,455,655.43	1,640,455,655.43
39202	Хуримтлагдсан элэгдэл		(312,523,883.55)	(366,216,778.77)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		438,785,363.00	298,778,818.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(352,388,851.52)	(15,029,458.58)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		820,177,211.40	760,796,407.09
39206	Хуримтлагдсан элэгдэл		(483,579,165.04)	(181,047,550.23)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		165,469,911.00	181,643,683.00
39208	Хуримтлагдсан элэгдэл		(122,079,120.75)	(54,085,792.95)
39209	Зам, гүүрийн байгууламж		93,233,800.00	68,351,800.00
39210	Хуримтлагдсан элэгдэл		(77,074,271.97)	(17,475,202.17)
39214	Бусад үндсэн хөрөнгө		135,843,778.52	145,682,966.72
39215	Хуримтлагдсан элэгдэл		(87,071,885.37)	(80,798,170.78)
39217	Ном		25,448,265.00	30,488,992.10
393	Биет бус хөрөнгө		682,862,000.14	695,148,299.94
39301	Программ хангамж		20,848,000.00	14,598,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(20,167,999.86)	(1,632,500.06)
39303	Бусад биет бус хөрөнгө		682,182,000.00	682,182,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,567,558,806.29	3,106,693,668.80
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		2,919,498,597.39	3,707,299,876.25
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9		1,656,488.04
413	Өглөг			1,656,488.04
4131	Ажилчидтай холбогдсон өглөг			1,656,488.04
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР			1,656,488.04
51	Засгийн газрын хувь оролцоо		2,919,498,597.39	3,705,643,388.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		1,505,912,180.56	1,505,912,180.56
51101	Өмч: - төрийн		1,505,912,180.56	1,505,912,180.56
512	Хуримтлагдсан үр дүн		264,247,392.73	1,050,392,183.55
5121	Өмнөх үеийн үр дүн		264,247,392.73	264,247,392.73
5122	Тайлант үеийн үр дүн			786,144,790.82
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,149,339,024.10	1,149,339,024.10
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,919,498,597.39	3,705,643,388.21
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		2,919,498,597.39	3,707,299,876.25

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Тод-руулга	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,738,685,067.75	3,270,504,606.66
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		2,520,665,500.00	2,980,717,740.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		2,520,665,500.00	2,980,717,740.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих			289,786,866.66
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/			289,786,866.66
1330	Төсвийн захирагчдаас		218,019,567.75	
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт		218,019,567.75	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		39,254,997.00	837,316,286.79
120	Нийтлэг татварын бус орлого		39,254,997.00	837,316,286.79
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		6,600,297.00	148,322,602.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		6,600,297.00	12,251,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих			136,071,402.00
120009	Бусад орлого		360,000.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		25,864,700.00	673,488,164.79
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		6,430,000.00	15,505,520.00
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2	2,777,940,064.75	4,107,820,893.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,772,089,335.54	3,321,676,102.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,660,713,247.54	3,240,592,702.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,784,409,895.94	2,147,351,157.72
210101	Үндсэн цалин		997,412,168.67	1,200,154,669.02
210102	Нэмэгдэл		637,978,498.25	796,247,329.23
210103	Унаа хоолны хөнгөлөлт		42,477,910.00	60,015,310.89
210104	Урамшуулал		106,541,319.02	90,933,848.58
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		223,853,600.00	259,828,380.77
210201	Тэтгэврийн даатгал		152,220,500.00	189,639,748.67
210202	Тэтгэмжийн даатгал		17,908,300.00	17,175,794.54
210203	ҮОМШӨ-ний даатгал		8,954,100.00	9,223,157.27
210204	Ажилгүйдлийн даатгал		8,954,100.00	9,223,157.27
210205	Эрүүл мэндийн даатгал		35,816,600.00	34,566,523.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		191,574,640.08	203,686,119.66
210301	Гэрэл, цахилгаан		31,665,827.92	40,418,477.23
210302	Түлш, халаалт		143,083,399.20	146,881,784.43
210303	Цэвэр, бохир ус		16,825,412.96	16,385,858.00
2104	Хангамж, бараа материалын зардал		2,773,600.00	
210401	Бичиг хэрэг		1,829,400.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		944,200.00	
2105	Нормативт зардал		79,842,400.00	109,918,701.00
210502	Хоол, хүнс		79,842,400.00	109,918,701.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		31,318,400.00	70,540,647.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		16,357,000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл			6,145,800.00
210604	Урсгал засвар		14,961,400.00	64,394,847.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		31,680,000.00	34,892,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		31,680,000.00	34,892,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		315,260,711.52	414,375,696.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		85,180,727.95	176,491,670.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		115,928,115.50	66,438,724.20
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		114,151,868.07	171,445,302.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		111,376,088.00	81,083,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		111,376,088.00	81,083,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		41,827,200.00	23,663,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		66,058,888.00	57,420,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		3,490,000.00	

II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	2,772,089,335.54	3,321,676,102.63
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		5,850,729.21	786,144,790.82
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		600,000.00	
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		600,000.00	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		(600,000.00)	
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		5,250,729.21	786,144,790.82

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,746,191,217.75	3,418,827,208.66
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,506,150.00	148,322,602.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,506,150.00	148,322,602.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,146,150.00	148,322,602.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,146,150.00	12,251,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		136,071,402.00
120009	Бусад орлого	360,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,738,685,067.75	3,270,504,606.66
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,520,665,500.00	2,980,717,740.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,520,665,500.00	2,980,717,740.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		289,786,866.66
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		289,786,866.66
1330	Төсвийн захирагчдаас	218,019,567.75	
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	218,019,567.75	
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,718,089,875.14	3,263,899,499.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,718,089,875.14	3,263,899,499.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,606,713,787.14	3,182,621,099.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,784,409,895.94	2,144,526,314.60
210101	Үндсэн цалин	997,412,168.67	1,192,069,931.18
210102	Нэмэгдэл	637,978,498.25	799,338,724.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,477,910.00	60,015,310.89
210104	Урамшуулал	106,541,319.02	93,102,347.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	223,853,600.00	269,078,689.37
210201	Тэтгэврийн даатгал	152,220,500.00	196,298,895.43
210202	Тэтгэмжийн даатгал	17,908,300.00	17,810,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,954,100.00	9,549,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,954,100.00	9,549,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	35,816,600.00	35,870,693.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	198,446,967.75	203,686,119.66
210301	Гэрэл, цахилгаан	33,563,111.85	40,418,477.23
210302	Түлш, халаалт	148,058,442.94	146,881,784.43
210303	Цэвэр, бохир ус	16,825,412.96	16,385,858.00
2105	Нормативт зардал	81,174,730.00	104,433,724.80
210502	Хоол, хүнс	81,174,730.00	104,433,724.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,046,400.00	88,923,747.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	16,570,000.00	11,930,200.00
210604	Урсгал засвар	7,476,400.00	76,993,547.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,680,000.00	56,607,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,680,000.00	56,607,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	263,102,193.45	315,364,904.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	120,058,277.95	215,860,990.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	143,043,915.50	99,503,914.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	111,376,088.00	81,278,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	111,376,088.00	81,083,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	41,827,200.00	23,663,400.00

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	66,058,888.00	57,420,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,490,000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		195,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		195,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	28,101,342.61	154,927,709.03
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		30,142,000.00
	Дотоод эх үүсвэрээр		30,142,000.00
222001	Тоног төхөөрөмж		18,665,000.00
223001	Бусад хөрөнгө		11,477,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		(30,142,000.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	28,101,342.61	124,785,709.03
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		27,741,342.61
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		152,527,051.64

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,505,912,180.56	1,149,339,024.10	264,247,392.73	2,919,498,597.39
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			786,144,790.82	786,144,790.82
19	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,505,912,180.56	1,149,339,024.10	1,050,392,183.55	3,705,643,388.21

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,345,251,300.00	3,270,504,606.66	74,746,693.34	97.8
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,017,498,900.00	2,980,717,740.00	36,781,160.00	98.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,017,498,900.00	2,980,717,740.00	36,781,160.00	98.8
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	327,752,400.00	289,786,866.66	37,965,533.34	88.4
132001	Орон нутгийн төсвөөс	327,752,400.00	289,786,866.66	37,965,533.34	88.4
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	142,804,200.00	148,127,602.00	(5,323,402.00)	103.7
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,732,800.00	12,056,200.00	(5,323,400.00)	179.1

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	136,071,400.00	136,071,402.00	(2.00)	100.0
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,488,055,500.00	3,418,632,208.66	69,423,291.34	98.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,488,055,500.00	3,263,704,499.63	224,351,000.37	93.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,374,374,800.00	3,182,621,099.63	191,753,700.37	94.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,154,794,000.00	2,144,526,314.60	10,267,685.40	99.5
210101	Үндсэн цалин	1,245,688,500.00	1,192,069,931.18	53,618,568.82	95.7
210102	Нэмэгдэл	831,690,300.00	799,338,724.67	32,351,575.33	96.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	77,415,200.00	60,015,310.89	17,399,889.11	77.5
210104	Урамшуулал		93,102,347.86	(93,102,347.86)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	274,713,200.00	269,078,689.37	5,634,510.63	97.9
210201	Тэтгэврийн даатгал	186,805,000.00	196,298,895.43	(9,493,895.43)	105.1
210202	Тэтгэмжийн даатгал	21,977,000.00	17,810,700.00	4,166,300.00	81.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,988,600.00	9,549,200.00	1,439,400.00	86.9
210204	Ажилгүйдлийн даатгал	10,988,600.00	9,549,200.00	1,439,400.00	86.9
210205	Эрүүл мэндийн даатгал	43,954,000.00	35,870,693.94	8,083,306.06	81.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	236,864,400.00	203,686,119.66	33,178,280.34	86.0
210301	Гэрэл, цахилгаан	68,643,500.00	40,418,477.23	28,225,022.77	58.9
210302	Түлш, халаалт	151,644,500.00	146,881,784.43	4,762,715.57	96.9
210303	Цэвэр, бохир ус	16,576,400.00	16,385,858.00	190,542.00	98.9
2105	Нормативт зардал	161,319,200.00	104,433,724.80	56,885,475.20	64.7
210502	Хоол, хүнс	161,319,200.00	104,433,724.80	56,885,475.20	64.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	89,067,600.00	88,923,747.00	143,853.00	99.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	12,072,300.00	11,930,200.00	142,100.00	98.8
210604	Урсгал засвар	76,995,300.00	76,993,547.00	1,753.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	105,454,600.00	56,607,600.00	48,847,000.00	53.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	105,454,600.00	56,607,600.00	48,847,000.00	53.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	352,161,800.00	315,364,904.20	36,796,895.80	89.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	248,593,800.00	215,860,990.00	32,732,810.00	86.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	103,568,000.00	99,503,914.20	4,064,085.80	96.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	113,680,700.00	81,083,400.00	32,597,300.00	71.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	113,680,700.00	81,083,400.00		71.3
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,663,400.00	23,663,400.00		100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	90,017,300.00	57,420,000.00		63.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		30,142,000.00	(30,142,000.00)	
	Дотоод эх үүсвэрээр		30,142,000.00	(30,142,000.00)	
222001	Тоног төхөөрөмж		18,665,000.00	(18,665,000.00)	
223001	Бусад хөрөнгө		11,477,000.00	(11,477,000.00)	
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	3,488,055,500.00	3,293,846,499.63	194,209,000.37	94.4
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		27,741,342.61	(27,741,342.61)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		152,527,051.64	(152,527,051.64)	
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО		1	1	
3	Төсвийн байгууллага		1	1	
5	АЖИЛЛАГСДЫН ТОО		61	61	
6	Удирдах ажилтан		1	1	
7	Гүйцэтгэх ажилтан		46	46	
8	Үйлчлэх ажилтан		12	12	
9	Гэрээт ажилтан		2	2	
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 965,768.5 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- *Тайлант жилд 800.0 мянган төгрөгийн малын хөдөлгөөнийг тайлан бүртгэлд тусгаагүй, шинэ төлийг үнэлж орлогод аваагүй,*
- *Барилга дансанд бүртгэлтэй 54,923.4 мянган төгрөгийн их засварыг капиталжуулан бүртгэхдээ тусдаа хөрөнгө мэтээр бүртгэсэн,*
- *Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 327 нэр төрлийн 910,045.0 мянган төгрөгийн хөрөнгийг /Нийт хөрөнгийн 4.3 хувь/ бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй.*

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, УСНББОУС-1 “*Санхүүгийн тайлангийн толилуулга агуулга*”-ийн 27-д “*Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой...*”, УСНББОУС-17 “*Үндсэн хөрөнгө*”-ийн ХЗУ<sup>1</sup>4-д “*... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй ...*”, 19<sup>2</sup>-д “*... хөрөнгөд тодорхой хэсгийг нэмэх ... буюу засвар үйлчилгээ хийхэд дараа гарсан өртөг зардлуудаас бүрдэнэ.*” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Үнэлгээ ба хуваарилалт*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт **45,369.3** мянган төгрөгийн 7 зөрчил<sup>3</sup> илэрснээс 9,184.3 мянган төгрөгийн 5 зөрчилд төлбөрийн акт, 36,185.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, биет бус хөрөнгөтэй холбоотой 1 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **45,369.3** мянган төгрөгийн материаллаг залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 17,648.4 мянган төгрөгөөр давсан тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

1. Тооцооллын алдаанаас шалтгаалан захирал С.Сувдаад ур чадварын нэмэгдэлд 3,988.2 мянган төгрөгийг, үр дүнгийн урамшуулалд 300.6 мянган төгрөгийг тус тус илүү бодож олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*”, гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

<sup>1</sup> ХЗУ-Хэрэгжүүлэх заавар удирдамж

<sup>2</sup> Байгууллага нь өөрийн бүх үндсэн хөрөнгийн өртөг зардлыг тэдгээрийн гарсан тэрхүү цаг хугацаанд үнэлнэ. Эдгээр өртөг зардал нь үндсэн хөрөнгийн зүйлсийг худалдан авах буюу барьж байгуулахад анх гарсан өртөг зардал болон хөрөнгөд тодорхой хэсгийг нэмэх, заримыг сольж орлуулах буюу засвар үйлчилгээ хийхэд дараа гарсан өртөг зардлуудаас бүрдэнэ.

<sup>3</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Сахилгын шийтгэл тооцогдсон мужаан В.Пүрэв-Очирт сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа болоогүй байхад ур чадварын нэмэгдэлд 619.2 мянган төгрөгийн цалин бодож олгосон. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8 дахь *“Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно”*, БШУС, ХНХ, СС-ын сайдын 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/35, А/10, 9 дүгээр хамтарсан тушаалын 3 дахь *“Багш ажилтанд ур чадварын нэмэгдэл олгоход дараах нийтлэг шалгуурыг харгалзана”* 3.2-д *“Ёс зүйн зөрчилгүй, сахилгын шийтгэлгүй байх”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Дотуур байрны багш П.Нарантуяад 1,272.6 мянган төгрөгийн мэргэшлийн зэргийн нэмэгдэл цалинг илүү бодож олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын 6 дахь *“Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдлийг зөвхөн тухайн мэргэжлээрээ ажиллаж байгаа хугацаанд нь олгоно.”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4. Тайлант онд өндөр насны тэтгэврээ тогтоолгон, төрийн албанаас бүрмөсөн чөлөөлөгдөж, гэрээгээр ажиллаж буй багш З.Энхжаргалд 403.9 мянган төгрөгийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт *“Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын 2 дахь “Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас ... бодож олгоно”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5. Зоорь болон дотуур байр түрээсэлсний орлогын 40 хувь болох 2,599.8 мянган төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй, түрээслэх зөвшөөрлийг ТӨБЗГ-аас аваагүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 тоот тогтоолын 2 дахь *“түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх хэмжээг нийт орлогын дүнгийн 40 /дөчин/ хувиар тогтоосугай”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Түрээсийн төлбөрийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### **3.2 Албан шаардлага**

1. Төлбөр тооцоог хянаж баталгаажуулаагүйгээс нийгмийн даатгалын тайланд цалинг илүү тайлагнан 36,185.0 мянган төгрөгийн НДШ-ийн авлага үүсгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь*

өмнө хянан, баталгаажуулах” Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр тооцоог урьдчилан хянах замаар авлага, өглөг үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Биет бус хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Биет бус хөрөнгийн бүртгэлд 682,182.0 мянган төгрөгийн 174100м2 хэмжээтэй 5 газар бүртгэлтэй боловч газрын гэрчилгээгээр 177576 м2 байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Биет бус хөрөнгийг бүртгэл тайланд бүрэн, зөв дүнгээр тусгаж байх зөвлөмж хүргүүлээ.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийг дансанд бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй	1	910,768.5	1	910,768.5			1	910,768.5				
Малын хөдөлгөөнийг бүртгэлд тусгаагүй	1	800.0	1	800.0			1	800.0				
Барилгыг капиталжуулахд	1	54,923.4			1	54,923.4	1	54,923.4				

аа буруу бүртгэсэн												
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>965,768.5</b>	<b>1</b>	<b>55,723.4</b>	<b>1</b>	<b>54,923.4</b>	<b>1</b>	<b>965,768.5</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тооцооллын алдаанаас нотлох дэмжих баримтгүйгээр илүү цалинг бодож олгосон	1	4,288.8	1	4,288.8								
Сахилгын шийтгэл тооцогдсон ажилтанд ур чадварын нэмэгдэл олгосон	1	619.2	1	619.2								
Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг илүү бодож олгосон	1	1,272.6	1	1,272.6								
Төрийн алба хаасны нэмэгдэл цалинг илүү бодож олгосон	1	403.9	1	403.9								
Түрээсийн орлогын 40%-ийг төсөвт төвлөрүүлээгүй	1	2,599.8	1	2,599.8								
Тооцоо нийлж баталгаажуулаа гүйгээс авлага үүсгэсэн	1	36,185.0			1	36,185.0						
Биет бус хөрөнгийг зөв дүнгээр тусгаагүй	1	-					1	-				
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>45,369.3</b>	<b>5</b>	<b>9,184.3</b>	<b>1</b>	<b>36,185.0</b>	<b>1</b>	<b>-</b>				

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд 11 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг огт мэдээлээгүй,	1	-					1	
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>					<b>1</b>	
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>-</b>					<b>1</b>	

## ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
<b>A</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>9</b>	<b>10</b>
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		